

ЗҮҮН ХОЙТ АЗИ СУДЛАЛ

Ч. Далай

Орчин үед дэлхийн улс орнууд урьд хэзээч байгаагүйгээр ойртон холбогдож, бие биенээс хамаарах явдал олон улсын хөгжлийн ерөнхий хандлага болж байна. Аливаа улс орнууд дэлхий нийтийн хэмжээгээр уялдлага холбоотой, харилцан хамааралтай оршихын зэрэгцээ өөр өөрсдийн амьдран буй тив болон бүс нутгийн хэмжээнд хүч бололцоогоо нэгтгэн тивийн буюу бүс нутгийнхаа тулгамдсан зорилгуудыг шийдвэрлэхэд чармайлтаа дайчлах эрмэлзлэл сүүлийн жилүүдэд улам хүч авах болов. Европ, Латин Америк, Африкийн болон Ази-Номхон далайн улс гүрнүүдийг хамарсан байгууллагууд байгуулагдахын зэрэгцээ тивийн аль нэг хэсгийн, өөрсдийн оршин байдаг бүс нутгийн хэмжээгээр улс төрийн яриа хэлцэл явуулах, эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн салбарт хамтран ажиллах, үйл ажиллагаагаа нэгтгэн зохицуулахад ихээхэн анхаарал тавих болжээ. Үүнд НҮБ-ын шугамаар байгуулагдсан олон байгууллага чухал үүрэг гүйцэтгэж байна. Ийнхүү дэлхийн янз бүрийн бүс нутгуудад регионализмын үзэл санаа дэлгэрч, амьдралд хэрэгжих болсон байна.

Тив дэлхийн уялдлага холбоог дагалдан бидний суудаг Ази тив, Номхон далайн сав газар бас л бүс нутгийн хамааралтай үйл явцад шилжиж, тэр нь жилээс жил тэлэн өргөжсөөр байна. Нийт Ази, Номхон далайн улсуудыг хамарсан НҮБ-ын эдийн засаг-нийгмийн байгууллагуудын хамтад өргөн уудам Ази, Номхон далайн бүс нутаг дотроо Зүүн, Зүүн өмнөд, Өмнөд, Өрнөд Ази болон Номхон далайн өмнөд нутаг гэх зэргээр тодорхой хэсгүүдэд хуваагдан тэдгээрт оршин буй орнууд өөр хоорондоо хүч чармайлтаа нэгтгэн хамтран ажиллах, бие биесийг дэмжих зорилгоор комисс, нийгэмлэг, бага хурал чуулган уулзалт гэх зэрэг янз бүрийн олон талын хамтын ажиллагааг явуулж байна.

Ази, Номхон далайн умард хэсэгт өөр өөр улс төрийн системтэй, харилцан сөргөлдөх үзэл суртлын байр суурьтай, голдуу их гүрнүүд оршдог учир байдал арай өвөрмөц юм. Сүүлийн жилүүдэд дэлхий дахины байдалд гарч байгаа нааштай уур амьсгалын нөлөөгөөр Азийн умарт хэсэгт хамаарагдах улс орнууд, ялангуяа их гүрнүүд (АНУ, ОХУ, БНХАУ, Япон) харилцаагаа аль болохоор хэвийн болгохыг чармайж сөргөлдөөний байдлаас зоригтой гарч итгэлцэлд тулгуурласан идэвхитэй хамтын үйл ажиллагаа явуулж эхэллээ. Энэхүү хоёр талын болон олон талын харилцан үйлдлийн явцад «Зүүн хойт Азийн бүс нутаг» гэдэг томъёолол зөвхөн газар зүйн ойлголт байхаа больж, бас улс төр, нийгэм-эдийн засгийн үйл ажиллагааны агуулгыг илэрхийлэх болж дэлхийн улс төр-эдийн засгийн хэллэгт байр сууриа нэгэнт эзлэх боллоо.

Энэ бүс нутаг Япон, БНСУ, БНАСАУ, БНХАУ, Монгол улс, ОХУ, АНУ, Канад зэрэг Ази тив, Номхон далайн умард хэсэгт орших найман улсаас бүрдэж байна. Тэгэхдээ энд оршдог улсуудын жишээлбэл БНХАУ-ын Хар мөрөн, Гирин, Ляонин муж, ӨМӨЗО-ны Хөлөн буйр, Хянган, Жирэм аймаг, Улаан хад хот; ОХУ-ын Сибирь, Алс дорнод Монгол улсын дорнод нутаг, АНУ ба Канадын номхон далайн эрэг орчмын нутаг зэргийг яг энэ бүс нутагт тухайлан хамруулж болох биз.

Ч. Далай —Зүүн хойт Ази судлалын төвийн захирал, түүхийн ухааны доктор, профессор.

«Хүйтэн дайн» төгсгөл болж, энэ бүс нутгийн их, бага улс гүрэн сайн хөршийн харилцаа, итгэлцэлийн замд орсноор урьд ашиглагдаагүй оаисан хамтын ажиллагааны нөөцүүдийг оүс нутгийн улсуудын цаашдын хөгжил дэвшлийн үйл хэрэгт зориулах бололцоо бий болсон юм. Гухайлбал ОХУ—АНУ, ОХУ—БНХАУ-ын харилцааны нөөц хөдөлгөөнд орж, хоер Солонгос аажимдаа нэгдэж, оүс нутгийн нэгэн нөлөөтэй хүчний төв болох төлөв харагдаж, зогсонги оаисан Япон-ОХУ-ын харилцааны нөөцийг оүс нутгийн нэгэн хүчирхэг бодлого болгон хэрэгжүүлэх зэрэг хүчин зүйлс шинээр бий оолж, Зүүн хойт Азийн оүс нутгийн орнуудын хооронд эдийн засаг, шинжлэх ухаан техникийн хамтын ажиллагаа, интеграцийг цаашид бүрэлдүүлэн тогтооход тус дөхөм үзүүлэх шинэ бололцоо нээгдсэн гэж үзүүштэн юм.

Бүс нутгийн улсуудын Засгийн газар, ард түмний хүчин чармайлтын явцад тэдгээрийн хоорондын хоер талын оолон олон талын хамтын ажиллагааны үндэс суурь нийгмийн амьдралын олон салаа мөчирт явагдаж, байнга өргөжих хандлагатай оолмоо.

Гэвч Ази, Номхон далайн бусад бүс нутагт бий болсон олон талын хамтын ажиллагааны байгууллагууд шиг биежин хэлбэржсэн алоан ёсны байгууллагууд Зүүн хойт Азийн бүс нутагт хараахан байгуулагдаагүйгээс олон талын санал бодол, бодит хэрэгцээг тусгасан чиглэл, зөвлөмж, тооцоо судалгаа, дүн шинжилгээ илт үгүйлэгдэж байгаа нь ойлгомжтой. Тус бүс нутгийн зарим орны төрийн зүтгэлтэн, Засгийн газар зэргээс бүс нутагтаа олон талын хамтын ажиллагааны шинэ бүтэц, механизм, байгууллагыг үүсгэн бий болгох, иймэрхүү асуудлыг олон талын уулзалтаар хэлэлцэх санал тавих болсон нь бодит байдал дээр биежиж байгаа хамтын ажиллагааг зохион байгуулалтын хэлбэрт оруулах гэсэн эрмэлзлэлийн илрэл бизээ.

Зүүн хойт Азийн бүс нутгийн улс орнуудын хамтын ажиллагааны байдал, хандлага иймэрхүү байгаа үед Монгол улс дотооддоо өөрчлөлт шинэчлэлтийг хэрэгжүүлж улс төр, эдийн засгийн хуучин тогтолцооноос шинэ тогтолцоонд шилжиж жинхэнэ ардчилал, бодит зах зээлийн хөгжүүлэх гэсэн шинэ замд орсон нь түүний өмнө олон улсын харилцааны субъект болох, Ази тив, юуны өмнө Зүүн хойт хэсгийн улс орнуудын хамтын ажиллагааны үйл явцад оролцох шинэ бололцоог нээжээ. Монгол улс гадаад харилцааны шинэ баримтлалыг боловсруулан, түүгээр удирдлага болгон урьдын олон улсын тусгаарлагдмал байдлаас гарч, дэлхийн бүх улс оронтой харилцан ашигтай байх зарчмын үндсэн дээр харилцах, тэгэхдээ юуны өмнө өөрийн оршин буй Азийн чиглэлд гадаад бодлого, үйл ажиллагаагаа төвлөрүүлэх чигийг баримтлах болсон юм.

Тивийн бүх улстай харилцааг тэлэн хөгжүүлэх биет бололцоо манай улсад үгүйг харгалзан үзэх үндсэн дээр манай гадаад харилцааны өргөжилт явагдсан юм. Урьдын уламжлал бүхий орнуудаас хоёр их хөрш ОХУ, БНХАУ-тай харилцах харилцааг онцлох, шинээр түншлэлийг хөгжүүлэхдээ манай цаашдын, ялангуяа эдийн засгийн хөгжилд бүх талын туслалцаа үзүүлэхүйц өргөн бололцоотой АНУ, Япон, Өмнөд Солонгос зэрэг улсуудын зүг анхаарлаа зүй ёсоор хандуулсан юм. Цаашид түншлэх эдгээр улсууд маань Зүүн хойт Азийн бүс нутагт багтаж буй улсууд билээ. Ийнхүү Ази руу чиглэсэн манай гадаад бодлогын нэг үндсэн чиглэл нь объектив байдлаар Зүүн хойт Азийн бүс нутгийн улсуудтай харилцах явдал боллоо.

Энэ бүс нутгийн улсуудтай нягт холбоо тогтоон хамтын ажиллагааг өрнүүлэхийг манай улс зорихдоо газар нутгийн ойр тал, урьд их бага хэмжээгээр тогтоосон уламжлалт харилцаа, тэдгээр орнууд

(ялангуяа шинэ түншүүд) манай өөрчлөн байгуулалтанд нааштай хандсан хандлага, мөн улсуудын техник, технологи болон аж ахуйг удирдах удирдлагын хөгжлийн төвшин болон бас бус хүчин зүйлсийг анхааран үзсэн болно.

Манай улс Зүүн хойт Азийн олон улсын харилцаа, хамтын ажиллагааны үйл хэрэгт оролцож эхлэхдээ эн тэргүүнд бүс нутгийн орон тус бүртэн хоёр талын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэн өргөтгөх, түүгээр дамжин цаашид олон талын хамтын ажиллагаа эдийн засгийн интеграцийн үйлст оролцох явдлыг анхаарсан юм. Сүүлийн хоёр жил гаруйн хугацаанд манай улсаас бүс нутгийн орнуудтай харилцааг өргөтгөх тодорхой алхмууд хийж, олонхитой нь төр, засгийн хэмжээнд төлөөлөгчид солилцон яриа хэлэлцээ хийж, заримтай нь худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн салбарт хэлэлцээр байгуулан хэрэгжүүлж байна.

Энэ бүгд нь манай улс бүс нутгийн орнуудтай харилцан үйлдлийн өргөн үйл явц, хамтын ажиллагаанд бодитой оролцох болсныг харуулж байна. Ийнхүү манай улсын гадаад бодлого, гадаад эдийн засгийн харилцааны үйлст чухал ач холбогдолтой шинэ чиглэл гарсан бөгөөд үүнийг Европ болон Азийн бусад бүс нутгийн улсуудтай хөгжүүлэх харилцаа, хамтын ажиллагаанаас дутуугүй анхааран үзэх нь манай цаашдын хөгжлийн эрх ашгаас урган гарч буй билээ.

Зүүн хойт Азийн улсуудтай тогтоон өргөтгөж буй улс төр, нийгэм эдийн засаг, соёлын хэлхээ холбоо, хамтын ажиллагааны үйл явц шинжлэх ухааны салбарт хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилтыг аяндаа дэвшүүлэн тавьсан юм. Бүс нутгийн орнуудад Ази, Номхон далай, Зүүн Азийн болон сүүлийн жилүүдэд Зүүн хойт Азийн асуудлыг судлах тусгайлсан эрдэм шинжилгээний байгууллага, төвүүд нийгмийн ухааны салбар дотор байгуулагдан ажиллаж өргөн судалгааны ажлыг явуулж байна. Эдгээр байгууллага, төвүүд бие биетэйгээ харилцах, хоёр талын болон олон талын хамтын ажиллагааг хөгжүүлэх, судалгаа шинжилгээний үр дүнг солилцох сонирхолтой ажиллаж байна.

Манай улсын эрдэм шинжилгээний байгууллагуудаас бүс нутгийн орнуудын ижил төрлийн байгууллагуудтай тогтоон хөгжүүлсэн холбоо хэлхээг агуулга, хэлбэрийн аль аль талаас өргөтгөн төрөлжүүлэх, үйл ажиллагааг нь идэвхжүүлэхийг шинэ нөхцөл байдал шаардаж байгаа юм.

Манай улсын гадаад харилцааны асуудлаар оролддог эрдэм шинжилгээний байгууллагууд тус улсад бүрэлдэн тогтож буй улс төр, эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн шинэ бүтцүүдийг тогтворжуулан бататгахад туслах явдал нэн чухал зорилт болж буй. Үүний зэрэгцээ, бүс нутгийн орнуудын хөгжил дэвшил, тэнд хуримтлагдсан туршлагыг судлан, манайд хэрэг болохуйц зүйлсийг эрдэм шинжилгээний том бага бүтээл, практик зөвлөмж зэрэг хэлбэрээр боловсруулахад судалгааны байгууллагууд их үүрэг гүйцэтгэх ёстой. Дашрамд тэмдэглэхэд бид шинээр хэлхээ холбоог хөгжүүлж буй улсууд бүү хэл, олон жил холбоотой байсан том хөршүүдийнхээ өнөөгийн байдлын талаар бага ойлголттой байгаа учир орон судлалыг бий болгон хөгжүүлэх нь чухал болж байна. Үүний хамт улс орныхоо өнөөгийн байдал, хэрэгжүүлж буй үйл ажиллагааныхаа талаар бүс нутгийн олон нийтэд мэдээлж, эх орноо сурталчлах явдал эрдэм шинжилгээний байгууллагуудын гүйцэтгэх бас нэг үүрэг мөн.

Энэ бүгдийг харгалзан ШУА-ийн удирдлага гадаад харилцааны судалгааны ажлыг өргөтгөн төрөлжүүлэх нь зүйтэй гэж үзсэн юм. Саяхан болтол гадаад харилцаатай холбогдсон эрдэм судлалын ажлыг

Дорно дахины судлалын хүрээлэн дагнан гүйцэтгэж байсан бол ШУА-ийн 1990 оны 12 дугаар сарын шийдвэрээр Зүүн хойт Азийн чиглэлд судалгаа явуулах шинэ бүтэц—«Зүүн хойт Ази судлалын төв»-ийг шинээр байгуулсан юм.

Тус төв 1991 онд эмхлэгдэн байгуулагдаж үйл ажиллагаагаа эхлэн судалгааны үндсэн чиглэлийг тодорхойлов. Төв эрдэм шинжилгээний ажлаа Зүүн хойт Азийн олон улсын байдал, орон судлалын асуудлууд, Монгол ба бүс нутгийн орнуудын харилцааны орчин үе, түүхийн асуудлууд гэсэн хоёр үндсэн чиглэлээр явуулан эхэлж судалгааны нэг сэдэвт зохиол, товхимол, өгүүлэл, хэлний суралцах зэргийг бэлтгэх ажилд анхаарлаа төвлөрүүлж заримыг нийтэлж эхлэв.

Бүс нутгийн ижил төрлийн эрдэм шинжилгээний байгууллагуудтай, тухайлбал ЗХУ (хуучин нэрээр), БНХАУ, АНУ, БНСУ-ын хэд хэдэн хүрээлэн, төвтэй холбоо тогтоон, төлөөлөгчид солилцон хамтын ажиллагааны төлөвлөгөөг тохиролцон, хэлэлцээр байгуулан, эрдэм шинжилгээний бага хурал, уулзалтад оролцон, өөртөө зохиов. Тус Төвийн эрдэмтэд: 1991 оны 5 дугаар сард Ази, Номхон далайн болон түүний умард бүс нутгийн энх тайван, аюулгүй байдал, хамтын ажиллагаа, ирээдүйн төлөв гэсэн асуудлаар Москвад болсон олон улсын бага хуралд (энэ хурлын үеэр тус Төв «Ази, Номхон далайн бүс нутгийн орнуудын хамтын ажиллагааны сангийн» гишүүн болсон); мөн сард ЗХУ-ын (хуучин нэрээр) Алс дорнодын бүс нутгийн асуудлаар АНУ-ын Гонолууд болсон олон улсын бага хуралд (мөн хурлын үеэр тус төв проф. Р. Скалапиногийн нэрэмжит сангийн гишүүн болсон); мөн оны 12 дугаар сард БНХАУ-ын Ази, Номхон далайн эдийн засгийн хүрээлэгнээс Бээжин хотод хуралдуулсан Зүүн хойт Азийн эдийн засгийн хамтын ажиллагааны иргэдийн нийгэмлэгийн анхдугаар хуралд тус тус оролцсон юм. 1991 оны дундуур манай Төв Дорно дахин, олон улсын судлалын хүрээлэнтэй хамтран тээвэр, холбоо, жуулчлалын асуудлаар Зүүн хойт Азийн орнуудын эрдэмтэд, мэргэжилтний уулзалт зохиов. Москвад өнгөрсөн оны 5 дугаар сард болсон бага хурлын үеэр тохиролцсон дагуу Бүс нутгийн 8 орны эрдэмтэд оролцсон олон улсын бага хурлыг БНСУ-ын Сеул хотын Генхийн их сургуультай хамтран энэ оны 7 дугаар сарын сүүлчээр Улаанбаатарт зохиохоор төлөвлөн бэлтгэж байна.

Эдгээр дурдсан зүйл бол Зүүн хойт Азийн орнуудыг судлах, тэдгээр орны эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтын ажиллагаа тогтоон хөгжүүлэхийн эхлэл бөгөөд энэ үйл ажил цаашид үргэлжлэх болно.

Зүүн хойт Ази судлалын төв өөрийн судалгааны ажлын явц, үр дүнг олон нийтэд хүргэн сурталчлах зорилгоор жилд хоёр удаа нийтлэгдэх «Зүүн хойт Ази судлал» сэтгүүлийг хэвлэн гаргах болж, түүний анхны дугаар нь уншигч Таны гар дээр очиж байна.

Сэтгүүлийн редакцийн төлөвлөж байгаагаар тус сэтгүүлийн хуудсанд:

- Онол-улс төрийн нийтлэг асуудлууд.
- Бүс нутгийн орнуудын орчин үеийн хөгжлийн байдал, төлөв,
- Бүс нутгийн ард түмний түүх, соёлын уламжлал, зан заншил, ахуй амьдралын сонирхолтой мэдээ материал.
- Бүс нутгийн нийгэм-улс төр, соёл-шинжлэх ухаан, аж ахуй-бизнесын зүтгэлтэн, нэрд гарсан хүмүүсийн үйл ажиллагаа, амьдралын хөрөг.
- Бүс нутгийн орнуудад нийтлэгдэж буй манай уншигчдын сонир-

хол татахуйц ном, зохиолын тухай шүүмж, зарим зохиолоос хэсэглэн авсан зүйлс.

— Монгол ба бүс нутгийн орнуудын хамтын ажиллагаа, эдийн засгийн интеграц, соёлын солилцоо.

— Монгол ба бүс нутгийн орнуудын гадаад бодлогын асуудал, дипломатын тодорхой үйл явдал.

— Аж үйлдвэрийн ба нүүдлийн соёл иргэншлийн асуудал.

— Монгол ба бүс нутгийн орнуудад болсон эрдэм шинжилгээний бага хурал, уулзалт, симпозиумын тухай мэдээ.

— Тэдгээр орны дотор болж буй онцлог үйл явдлын хэлхээ гэх мэтийн эрдэм шинжилгээ-судалгааны, түүх, онол-улс төрийн болон хүн зоны амьдрал, аж байдлын тухай өгүүлэл, материал, хэрэглэгдэхүүн шүүмж, мэдээ, лавламж зэрэг янз бүрийн материал нийтлэгдэх болно.

Эрхэм уншигчид Зүүн хойт Азийн улс орнууд, ард түмний талаар ойлголтоо баяжуулж, тэнд өрнөж буй үйл явдлын талаар мэдэж байхыг хүсвэл манай «Зүүн хойт Ази судлал» сэтгүүлийг захиалан уншиж байхыг урьж байна.

Манай сэтгүүлийг хэвлүүлэхэд гүн туслалцаа үзүүлж байгаа «Лавай» пүүс, «Эрдэм» пүүсийн хамт олонд гүн талархалаа илэрхийлэхийг энэ дашрамд хүсч байна.